

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 13.020

Байгаль орчныг хамгаалах стандартын систем Монгол орны уур амьсгал үндсэн үзүүлэлт	MNS 4191:1993
Климат Монголии Основные характеристики	

Үндэсний стандартчилал, хэмжилзүйн төвийн Тэргүүлэгчдийн хурлын 25 тоот тогтоолын дагуу 1994 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөнө.

Энэхүү стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

1 Ерөнхий зүйл

1.1 Энэ стандарт монгол орны уур амьсгалын үндсэн үзүүлэлт /агаарын температур, хур тунадас, чийг, дарал, салхины хурд, нарны гийгүүлэл/-ийн сар жилийн дунджийг сүүлийн 30 жилээр тогтооно.

1.2 Энэхүү нормыг өмчийн хэлбэрийг харгалзахгүй бүх аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний байгууллага, төв эдийн засгийн тооцоо судалгаа, норм норматив, төсөл боловсруулахад үндэслэл болгоно.

1.3 Стандартыг улс, хоршооллын болон хувийн холбогдох бүх аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтан дагаж мөрдөх бөгөөд стандартчилсан тоо баримтыг ойлголцоо тоогоор сольж хэрэглэж болохгүй.

1.4 Барилгын норм ба дүрэм 2.01, 01-93 /БНСД/-д заагдсанаас бусад үйл ажиллагаанд уур амьсгалын уг нормыг үндэслэл болгоно.

2 Үндсэн үзүүлэлт

2.1 Монгол орны уур амьсгалын бүтэцэд дараах үзүүлэлтийг хамруулна.

- Агаарын дундаж температур, C^0 /1-р хүснэгт/
- Агаарын үнэмлэхүй их температур C^0 /2-р хүснэгт/
- Агаарын үнэмлэхүй бага температур C^0 /3-р хүснэгт/
- Агаарын хамгийн их температурын дундаж C^0 /4-р хүснэгт/
- Агаарын хамгийн бага температурын дундаж C^0 /5-р хүснэгт/
- Агаарын даралт, г Па /6-р хүснэгт/
- Агаарын үнэмлэхүй чийгийн дундаж, г Па /7-р хүснэгт/
- Хур тунадасны нийлбэр, мм /8-р хүснэгт/
- 1мм ба түүнээс их тунадастай өдрийн тоо /9-р хүснэгт/
- салхины дундаж хурд, м/с /10-р хүснэгт/
- нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа, /цаг/ /11-р хүснэгт/

Тайлбар: Температурын үзүүлэлтийг "СИ" системийн нэгжид шилжүүлэхдээ "273-15к"-ийг нэмж тооцно.

ТӨГСӨВ.